


Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ үнэлгээг Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолийн хавсралтаар баталсан **“БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙХ НИЙТЛЭГ ЖУРАМ”**-д заасан үнэлгээ хийх аргачлалын дагуу гүйцэтгэлээ.

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 2019 оны жилийн эцсийн хэрэгжилтийг нэгтгэн, Засгийн газрын 2017 оны 03 сарын 15-ны өдрийн 89-р тогтоолоор баталсан **БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙХ НИЙТЛЭГ ЖУРАМ**-д заасан үнэлгээ өгөх зааврын дагуу үнэлж үзэхэд нийт 60 заалтын биелэлт 92,7 хувьтай хэрэгжиж байна.

Хэрэгжилтийг үнэлгээний үе шат тус бүрээр нь авч үзвэл:

- Бүрэн хэрэгжсэн 43 заалт нь нийт заалтын 71,8 хувийг
- Хэрэгжих шатандаа байгаа 7 заалт нь 11,7 хувийг
- Хэрэгжилт хангалтгүй хэрэгжсэн 1 заалт нь 1,6 хувийг
- Хэрэгжээгүй 1 заалт нь нийт заалтын 1,6 хувийг
- Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй 8 заалт 13,3 хувийг эзэлсэн байна.



Хэрэгжилтийг товчоогоор харууллаа.

Агуулга		Үүнээс							
	Бүгд	Монгол улсын хууль	УИХ-ын тогтоол	УИХ-ын байнгын хорооны тогтоол	Ерөнхийлөгчийн зарлиг	Засгийн газрын тогтоол	Засгийн газрын хуралдааны тэмдэглэл	Засгийн газрын албан даалгавар	ЗГХЭГ-ийн даргын тушаал
Хяналтад авсан нийт шийдвэрийн тоо		36	1	1	1	24	3	4	1
Хяналтад авсан нийт зүйл, заалтын тоо		60	1	1	1	2	38	5	11
Үүнээс	Бүрэн хэрэгжсэн /100%/	43				2	30	4	6
	Хэрэгжих шатандаа 70%	7			1		2	1	3
	Хэрэгжилт хангалтгүй 30%	1				1			
	Хэрэгжээгүй 0%	1	1						
	Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй	8		1		5		2	
	Хяналтнаас хасах санал	42				1	31	5	4
БИЕЛЭЛТИЙН ДҮН /Хувь/		92,7	0	-	70	100	96	94	90

Аймгийн түвшинд:

Дараах даалгасан заалтуудыг нягтлан судалж төлөвлөгөө гарган хэрэгжүүлж ажиллана уу?

1. Авто замын тухай /Шинэчилсэн найруулга / 2017-05-11 Дугаар 2017.05.11

Ажлын хэсэг төлөвлөгөө гарган, сум, багийн удирдлагуудтай хамтран хэлэлцүүлэг, санал авах ажлыг зохион байгуулах, удирдлага зохион байгуулалтаар хангах, 3 дугаар улиралдаа багтааж ИТХ-аар төслийг батлуулах

2. Улс, орон нутгийн тусгай сан хөмрөгийн улсын тооллогын дүнгийн мөрөөр авах зарим арга хэмжээний тухай 2015-05-18 Дугаар 2015_195

Орон нутгийн өмчид авах асуудлыг даруй судалж, шат шатандаа хэрэгжүүлэх чиглэлийг тодорхой томъёолсон төлөвлөгөө гарган, хяналт тавин, улирал бүр мэдээлж ажиллах

3. Мал, махны экспортыг нэмэгдүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2017-11-24 Дугаар 2017_318

Тусгаарлах бүс байгуулах боломж, нөхцлийг дахин судлах

Мах борлуулдаг ААН-үүдэд тогтоолын талаар ойлголт өгөх

4. 2019_03. Төрийн үйлчилгээнд цахим төлбөр тооцоог нэвтрүүлэх тухай /2019-10-16 / ЗГ-ын албан даалгавар

1.1. Иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээний төлбөр тооцоонд "Цахим төлбөрийн баримтын систем" /ebarimt/ нэвтрүүлэх ажлыг 2019 онд багтаан иргэдэд чирэгдэл үүсгэлгүйгээр шуурхай зохион байгуулах.

1.2. Цахим төлбөр тооцоонд шилжихтэй холбоотойгоор үйлчилгээний ажилтнуудыг сургаж бэлтгэх, төлбөр тооцооны системийн талаар иргэдэд сурталчилан таниулах.

1.3. Цахим гарын үсгийн хуулийн хэрэгжилтийг хангаж, төрийн үйлчилгээнд тоон гарын үсгийг нэвтрүүлэх.

1.4. Төрийн үйлчилгээний шимтгэл, төлбөрийн хэмжээг бууруулах. Хугацаа болоогүй

1.5. Төрийн үйлчилгээнд цахим төлбөр тооцоог нэвтрүүлэхтэй холбогдуулан шаардлагатай бол эрхлэх асуудлын хүрээнд болон нутаг дэвсгэрийн хэмжээнд мөрдөж байгаа эрх зүйн актуудад зохих өөрчлөлт оруулах.

3.. Албан даалгаврын хэрэгжилтийг дүгнэж, тайланг улирал бүр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт ирүүлэхийг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт, албан даалгаврын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг улирал тутам Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Л.Оюун-Эрдэнэд даалгав

5. Төрийн үйлчилгээний талаар авах зарим арга хэмжээний тухай 2019-04-17 2019_149/

Шийдвэрүүдийг судалж төлөвлөгөө гарган ажиллах